



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/04

Пионер толгой

┌ Шуурхай штаб байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ зүйлийн 27¹.1.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны А/36 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын даргын 2022 оны 06 тоот тушаал, аймгийн Онцгой комиссын 2022 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын хэмжээнд цаг агаар, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор сумын Онцгой комиссын “Зуд, өвөлжилт хүндэрсэн үед ажиллах шуурхай штаб”-ыг хавсралтаар томилсугай.

2. Холбогдох дээд шатны байгууллага болон иргэд, олон нийтэд мэдээ, мэдээллийг нэгдсэн байдлаар хүргэн ажиллахыг Сумын онцгой комиссын шуурхай штабын даргад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, сумын Онцгой комиссын орлогч дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

642201155

Сумын Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын 12-ны өдрийн
А/04 тоот захирамжийн хавсралт



ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай штабын дарга:	Э.Сүглэгмаа	Засаг даргын орлогч
Гишүүд:	М.Ариунсан	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, малын үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн
	Р.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
	Э.Хас-Очир	Мал эмнэлгийн улсын байцаагч
	Б.Мөнхдалай	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Г.Сүхбаатар	Эрүүл мэндийн төвийн дарга
	З.Отгонбилэг	Цаг уурын ажилтан
	Д.Цэцэгээ	Ерөнхий боловсролын сургуулийн захирал
	Э.Цэрэнханд	Цэцэрлэгийн эрхлэгч
	Б.Бадамцэцэг	Соёлын төвийн эрхлэгч
	Б.Лувсаншийрэв	Цэнгэл 1 дүгээр багийн Засаг дарга
	Д.Мөнхчулуун	Давааны ам 2 дугаар багийн Засаг дарга
	Д.Болд-Аюуш	Буга 3 дугаар багийн Засаг дарга
	Б.Баттулга	Хөвийн ам 4 дүгээр багийн Засаг дарга
	Ч.Батцэцэг	Пионер толгой 5 дугаар багийн Засаг дарга

оОо